

Криптовалютын бүртгэлийн асуудал

The Issue of Cryptocurrency Reporting

Н. Дамдиндорж¹, Э. Ундармаа²

Хураангуй

Дэлхий дахинд сүүлийн арван жилд хурдацтай хөгжиж, хамрах хүрээгээ тэлж байгаа төлбөрийн хэрэгслийн нэг бол криптовалюта буюу Ecash (Chaum, 1983) цахим мөнгөний талаарх анхны ойлголт 1983 онд үүссэн. Харин 1989 оноос DigiCash гэсэн анхны цахим төлбөр тооцооны хэрэгслийг АНУ-ын бичил төлбөр тооцоонд хэрэглэж эхэлсэн байна. Үүнээс хойш Bitcoin гэх криптовалюта үүссэн бөгөөд арав гаруй жилийн дотор нэг их наяд ам долларын зах зээлийн үнэлгээтэй, дэлхийн криптовалютын зах зээлийнхээ 60 гаруй хувийг дангаар эзэлж буй криптовалюта болоод байна. Тиймээс энэ зах зээл дээр байгаа криптовалютуудыг хэрхэн бүртгэж, санхүүгийн тайланд тусгах талаар судлахыг зорьсон ба одоогийн байдлаар санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнах талаар стандарт, хууль эрх зүйн актууд монголд гэлтгүй дэлхийн улс орнуудад ховор байна. Судлаач бидний судалгаа болон төсөөлж байгаагаар криптовалютыг биет бус хөрөнгө болон бараа материал байдлаар бүртгэж, тайлагнах боломжтой бөгөөд ирээдүйд магадгүй уламжлалт мөнгөн тэмдэгтийг орлож төлбөрийн хэрэгсэл болж, мөнгөн хөрөнгө байдлаар бүртгэж, тайлагнахыг үгүйсгэхгүй юм.

Түлхүүр үгс: криптовалюта, койн, токен, санхүүгийн тайлан

Abstract

The first concept of cryptocurrency or e-money was established in 1983, one of the fastest growing and expanding payment instruments in the world in the last decade. In 1989, DigiCash, the first electronic payment instrument, was introduced for micro-payments in the U.S. Since then, a cryptocurrency called Bitcoin has emerged, with a market capitalization of more than \$1 trillion and more than 40 percent of the world's cryptocurrency market in just over a decade. Therefore, we aimed to study how to record and report cryptocurrencies for the financial statements in this market. Currently, standards and legal acts on reporting in the financial statements are rare not only in Mongolia but also in other countries of the world. Our hypothesis suggest that cryptocurrencies can be recorded and reported as intangible assets and inventories. In the future they may be replaced by traditional currencies as a means of payment and recorded and reported as cash.

Keywords: cryptocurrency, coin, token, financial statement

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: damdindorj.n@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: undarmaae@num.edu.mn

Оршил

Крипто гэдэг үг нь “kryptós” гэсэн эртний Грек үгнээс гаралтай бөгөөд орчуулбал нуугдмал эсвэл хувийн гэсэн утгыг илэрхийлдэг байна. Өнөөгийн байдлаар криптовалютын зах зээл дээр 9 мянга шахам криптовалют, 1.7 их наяд⁵ ам долларын үнэлгээтэй байгаа бөгөөд цаашид зах зээлийн багтаамж болон койнуудын тоо нэмэгдсээр байх боломжтой юм. Яагаад криптовалют ингэж хурдацтай хөгжиж, өргөн цар хүрээг хамраад байна вэ гэвэл ирээдүйд төлбөр тооцоо, шилжүүлэг гэх мэт банкны систем болон уламжлалт мөнгийг орлох технологийн болоод үр ашгийн хувьд боломжтой гэж дэлхий нийт харж байна. Маш өндөр нууцлал, төвлөрсөн бус үйлчилгээ, аливаа зохицуулагчид болон улс төрийн институт нийлүүлэлтийг нь хянадаггүй гэх мэт олон давуу талууд байна. Манай улсын хувьд 2017/10/01-нд Дижитал Эксчейнж Монголиа ХХК анхны криптовалютын биржийг⁶ үүсгэн байгуулж, үйл ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлж байна. Мөн Ард Бит ХХК нь 2017 онд АрдКойн (ARDX) гэж анхны криптовалют


гаргаж өдгөө Монголын болон гадаадын бирж⁷ дээр арилжаалагдаж эхлээд байна. Тиймээс бид криптовалютын талаар танин мэдэж, бүртгэл тайлагналын асуудлыг судалж үзэхээр шийдсэн юм.

Криптовалютын өнөөгийн байдал

Одоогийн байдлаар зах зээл дээр 8,899 криптовалют 1,771 тэрбум долларын үнэлгээтэйгээр оршин байгаа бөгөөд үүний 60.4 хувийг биткойн дангаар эзэлж байна. Дүрслэл 1-ээс харвал үндсэндээ эхний 10 криптовалют нийт зах зээлийн 85 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 15 хувийг бусад 8,889 криптовалютын үнэлгээ эзэлж байна. Харин эдгээр криптовалютыг арилжаалдаг 304 бирж байгаагаас хамгийн олон хандалттай, хамгийн өндөр арилжааны дүнтэй, хамгийн өндөр рейтингтэй биржүүдээс дурдвал дараах байдалтай байна (Хүснэгт 1).

2020/12/31-ний өдрийн байдлаар дэлхийн 130 гаруй улс орон криптовалютыг зохицуулах хууль эрх зүйн актуудыг⁸ батлаад байгаа бөгөөд Америк тивийн 15 улс, Карибийн тэнгисийн 14 улс, Европ тивийн 49 улс, Африк тивийн 24 улс, Ази тивийн 27 улс багтаж байна. Эдгээр улсуудын хууль эрх зүйн актуудын нийтлэг шинж нь мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхгүй байх зохицуулалтыг тусгасан ба мөн криптовалютын татварын асуудлыг зохицуулсан байна. Татварын асуудал нь криптовалютыг олборлож байгаа эсвэл борлуулж байгаагаас нь хамааруулан татварын сууриа тооцож байна. Жишээлбэл, Их Британи хуулийн этгээдэд орлогын татвар, хувь хүнд хөрөнгийн татвар; Швейцарь улс гадаад

Дүрслэл 1. Зах зээлд эзлэх хувь



³ www.coinmarketcap.com

⁴ www.trade.mn

⁵ www.stex.com

⁶ https://www.loc.gov/law/help/cryptocurrency/world-survey.php

Хүснэгт 1. Биржийн мэдээлэл

№	Биржийн нэр	Нэг өдрийн арилжаа	Нэг өдрийн оролцогчид	Криптовалютын хослолын тоо	Арилжаанд оролцох валют
1	Binance	\$ 21,356,192,585	14,296,860	1,138	46
2	Coinbase Pro	\$ 2,118,827,005	2,331,017	142	3
3	Kraken	\$ 1,061,078,068	2,266,008	284	7
4	Bitfinex	\$ 1,137,868,375	458,234	279	4
5	Huobi Global	\$ 6,364,413,798	831,763	930	50
6	Kucoin	\$ 864,736,857	578,775	624	токен

Эх сурвалж: www.coinmarketcap.com

валют байдлаар; Израйль улс хөрөнгө байдлаар; Болгар улс санхүүгийн хөрөнгө байдлаар; Дани, Аргентин, Испани улсууд орлогын татвар ногдуулж байна.

Монголын криптовалютын бирж (www.trade.mn) дээр 9 ширхэг криптовалютыг төгрөгөөр арилжаалж байгаа бөгөөд BTC, ETH, LTC, XRP зэрэг голлох криптовалютаудаас гадна ARDX буюу АрдКойн мөн арилжаалагдаж байна. Хууль эрх зүйн хувьд “Сандбокс зохицуулалтын орчны журам”-ыг⁹ баталснаар санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг зах зээлд нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой хугацаанд турших зохицуулалтын орчинг бий болгох, оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор баталжээ.

Эдгээр мэдээллээс харахад Монгол улс болон дэлхийн бусад улс орнуудад криптовалютын зохицуулалтын хууль, дүрэм журам батлагдаж байгаа боловч бүртгэл, тайлагналтай холбоотой хууль эрх зүйн актууд одоогоор байхгүй байна.

Хавсралт 1-д улс орнуудын хууль дүрэм журмын агуулгыг харуулсан болно.

Криптовалютыг бүртгэж, тайлагнах нь

Хэдийгээр криптовалютад шууд хэрэглэгдэх стандарт байхгүй боловч түүнийг ямар зорилгоор хэрхэн ашиглаж байгаагаас нь хамааруулан ангилж, одоо байгаа стандартуудын хүрээнд хэрхэн бүртгэж, тайлагнаж болохыг судаллаа. Криптовалютыг технологийн талаас нь койн болон токен гэж ангилах бөгөөд койн нь өөрийн гэсэн блокчейн дээр суурилсан байдаг бол токен нь өмнө нь бий болсон блокчейн¹⁰ дээр бий болдгоороо ялгаатай. Харин бүртгэл тайлагналын хувьд онцгой ялгаа байхгүй бөгөөд зах зээл нь хөрөнгийн зах зээлтэй ижил хөрөнгө оруулагч, санхүүжигч болон зуучлагч буюу биржүүд оролцдог бөгөөд анх койн болон токенээ нийтэд санал болгож байгаа компанийг ICO (Initial Coin Offering) хийх гэж нэрлэдэг.

Тиймээс санхүүжигч компанийн бүртгэл тайлагналыг эхлээд судалж үзвэл ICO хийж байгаа компани нь тухайн токений төрлөөс хамаарч өөр өөр байдлаар бүртгэж болох юм. Үүнд:

1. Security token - Компани токен гаргаснаар *мөнгө болон санхүүгийн хөрөнгө өгөх, санхүүгийн хэрэглүүрийг*

⁷ Монгол Банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаал, 2021/03/01

⁸ Ethereum, Neo, Waves, Lisk, Strtis гэх мэт.

Хүснэгт 2. Security token-ийн бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Санхүүгийн өр төлбөр СТОУС 9	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Security token	НББОУС 32-ийн 11-р параграф	Мөнгөн хөрөнгө	Санхүүгийн өр төлбөр*	Бодит үнэ цэнээр нь бүртгэнэ	Хорогдуулсан өртгөөр тайлагнана

* - мөнгө болон санхүүгийн хөрөнгө өгөх үүрэг

Хүснэгт 3. Equity token-ийн бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Өмчийн хэрэглүүр НББОУС 32	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Equity token	НББОУС 32-ийн 11-р параграф	Мөнгөн хөрөнгө	Өмчийн хэрэглүүр**	Хүлээн авсан мөнгөн дүн	Дансны үнээр тайлагнана

** - бүх өр төлбөрийг хассаны дараа аж ахуйн нэгжийн хөрөнгөнд

Хүснэгт 4. Utility token-ийн бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Гэрээний өр төлбөр СТОУС 15	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Utility token	СТОУС 15-ын 9-р параграф	Мөнгөн хөрөнгө	Гэрээний өр төлбөр***	Хүлээн авсан мөнгөн дүн	Үлдэгдэл гүйцэтгэлийн үүрэгт хамаарах

*** - худалдан авагчаас төлбөр хүлээн авч бараа, үйлчилгээ нийлүүлэх нэгжийн үүрэг

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Орлого СТОУС 15	
				Гарцын арга	Орцын арга
Utility token	СТОУС 15-ын 35, 36, 37-р параграф	Гэрээний өр төлбөр	Орлого****	Гүйцэтгэлийн судалгаа, хүрсэн үр дүнгийн үнэлгээ, явцын амжилт, зарцуулсан хугацаа, үйлдвэрлэсэн буюу нийлүүлсэн тоо	Зарцуулсан нөөц, хөдөлмөр цаг, гарсан өртөг, зарцуулсан хугацаа, ашигласан машин цаг, опционы хугацаа дуусах үед

**** - хөрөнгийн өсөлт, өр төлбөрийн бууралт хэлбэрээр бий болсон эдийн засгийн үр өгөөжийн өсөлт

тааламжгүй нөхцөлөөр өөр аж ахуйн нэгжтэй солилцох үүрэг хүлээх эсвэл өөрийн өмчийн хэрэгслээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээний¹¹ үүрэг хүлээж байвал санхүүгийн өр төлбөр гэж ангилаад Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 9-ийн дагуу дараах байдлаар бүртгэж, тайлагнана (Хүснэгт 2).

2. Equity token - Компани токен гаргаснаар бүх өр төлбөрийг хассаны дараа аж ахуйн нэгжийн хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлэх гэрээний үүрэг хүлээж байвал өмчийн хэрэглүүрт

ангилж, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 32-ын дагуу бүртгэж тайлагнах нь зүйтэй гэж үзэв (Хүснэгт 3).

3. Utility token - Компани токен гаргаснаар бүтээгдэхүүн нийлүүлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх гэрээний үүрэг хүлээж байвал худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого гэж үзэн СТОУС 15-ын дагуу бүртгэж, тайлагнах нь зохистой юм (Хүснэгт 4).

4. Дээрх тодорхойлолтуудын аль нэгэнд хамаарахгүй токен байвал НББОУС 8¹²-ийн дагуу оновчтой арга хандлагыг

⁹ НББОУС 32, 11-р параграфт

Хүснэгт 5. Бусад токенийн бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Орлого СТОУС 15	
				Гарцын арга	Орцын арга
Бусад токен	СТОУС 15-ын 35, 36, 37-р параграф	Мөнгөн хөрөнгө	Орлого****	Сонгогдсон аргаар	Сонгогдсон аргаар

**** - хөрөнгийн өсөлт, өр төлбөрийн бууралт хэлбэрээр бий болсон эдийн засгийн үр өгөөжийн өсөлт

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Нөөц НББОУС 37	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Бусад токен	НББОУС 37-ын 10-р параграф	Мөнгөн хөрөнгө	Нөөц*****	Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ	Хорогдуулсан үнэ цэнэ (Санхүүгийн зардлаар)

***** - тодорхой бус хугацаа эсвэл дүн бүхий өр төлбөр

тодорхойлж, бүртгэж тайлагнаж болох юм. Магадгүй НББОУС 37-ийн дагуу тодорхой бус хугацаа эсвэл дүн бүхий өр төлбөрөөр ангилж нөөц эсвэл үүргийн дүнг хангалттай найдвартай хэмжих боломжгүй ба үүргийг барагдуулах эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлал бага гэж үзэн болзошгүй өр төлбөрөөр ангилан тайлагнаж, тодруулгыг хийвэл илүү нийцтэй байж болно (Хүснэгт 5).

Токений төрлөөс хамаарч Хүснэгт 2-оос Хүснэгт 5-д үзүүлсэнчлэн өөр өөр байдлаар бүртгэж, тайлагнаж болохыг харууллаа.

Харин хөрөнгө оруулагч буюу токенийг эзэмшиж байгаа талын бүртгэл тайлагнал нь түүний зорилгоос хамааралтай байх бөгөөд дараах стандартууд түүний бүртгэл тайлагналтай холбоотой байж болох юм. Үүнд:

1. НББОУС 7 - "Мөнгөн гүйлгээний тайлан" стандартад "мөнгөтэй адилтгах хөрөнгө гэдэг нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай

хөрөнгө оруулалтыг хэлнэ" гэж заасан байдаг. Дээрх тодорхойлолтоос гадна мөнгө нь таваарын солилцооны хэрэгсэл байх бөгөөд түүнийг гаргагч эдгээд нь хууль ёсны байх юм. Энэ бүхнээс үзэхэд криптовалюта нь таваарын солилцооны хэрэгсэл болж байгаа¹³, мөнгөнд чөлөөтэй хөрвөх чадвартай болж байгаа гэх мэт тодорхойлолтуудын агуулгыг хангаж байгаа боловч үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэл өндөр хэвээр байгаа, мөн гаргагч нь хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болж чадахгүй байгаагаас шалтгаалж одоохондоо мөнгөн хөрөнгө гэж үзэх боломжгүй байна.

2. СТОУС 32 - "Санхүүгийн хэрэглүүр" стандартад "мөнгө, өөр аж ахуйн нэгжийн өмчийн хэрэглүүр, өөр аж ахуйн нэгжээс мөнгө, бусад санхүүгийн хөрөнгө авах эсвэл өөрт ашигтай нөхцөлөөр солилцох гэрээний эрхийг хэлнэ" гэж заажээ. Хэрэв гэрээг эзэмшигчийн өмнө хариуцлага хүлээж байвал тухайн криптовалютыг санхүүгийн хөрөнгө гэж ангилаад дараах байдлаар бүртгэж, тайлагнаж болох юм (Хүснэгт 6).

¹⁰ НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа

¹¹ НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа

Хүснэгт 6. Санхүүгийн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Санхүүгийн хөрөнгө СТОУС 9	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Security, Equity token	НББОУС 32-ын 11-р параграф	Санхүүгийн хөрөнгө	Мөнгөн хөрөнгө	Худалдан авсан үнэ дээр худалдан авалттай шууд холбоотой гарсан зардлын нийлбэр	Хорогдуулсан өртөг, Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ

Хүснэгт 7. Бараа материалын бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Бараа материал НББОУС 2	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Бүх токен	НББОУС 2-ын 6-р параграф	Бараа материал	Мөнгөн хөрөнгө	Худалдан авсан үнэ дээр одоогийн байршил, төлөвт оруулахтай холбоотой гарсан зардал	Өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь

Хүснэгт 8. Биет бус хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Төрөл	Шалгуур	Дебет данс	Кредит данс	Биет бус хөрөнгө НББОУС 38	
				Анхны хэмжилт	Дараа тайлант үеийн хэмжилт
Бүх токен	НББОУС 38-ын 8-17-р параграф	Биет бус хөрөнгө	Мөнгөн хөрөнгө	Өртөг, бодит үнэ цэнэ, шаардлага хангасан зардлын нийлбэр ¹⁴	Бодит үнэ цэнээс хуримтлагдсан хорогдол, үнэ цэнийн бууралтын гарзыг хассан

3. НББОУС 2 - "Бараа материал" стандартад "бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа, борлуулахын тулд үйлдвэрлэлийн процессод байгаа, үйлдвэрийн процесс эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал, хангамжийн зүйлсийг хэлнэ" гэж заасан. Тиймээс криптовалютын зах зээлийн бизнесийн хэвийн үйл ажиллагаа гэдэгт олборлогч болон брокерийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд хамаарна (Хүснэгт 7).

4. НББОУС 38 - "Биет бус хөрөнгө" стандартад "биет шинж чанаргүй,

тодорхойлж болохуйц мөнгөн бус хөрөнгийг хэлнэ" гэсэн байдаг бөгөөд криптовалютын шинж чанарт хамгийн тохиромжтой байж болох тодорхойлолт юм. Нэгэнт хөрөнгө гэж ангилсан бол ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж байх, мөн өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх ёстой (Хүснэгт 8).

Мөн түүнчлэн НББОУС 40 - "Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө" стандарт хэрэглэгдэж болох боловч стандартад тусгайлан үл хөдлөх хөрөнгө гэж заасан учраас криптовалютын бүртгэл тайлагналд хязгаарлах заалт болж байна.

¹² НББОУС 38-ын 57-62-р параграфт заасан шаардлагыг хангах хөгжүүлэлтийн зардал байна.

Дүгнэлт, санал

Бид судалгааны ажилдаа криптовалютыг гаргагч буюу санхүүжигч байгууллага нөгөө талаас криптовалютыг эзэмшиж байгаа буюу хөрөнгө оруулагч байгууллагын талаас тус тусад нь бүртгэлийн асуудлыг нь судалж үзлээ. Санхүүжигч байгууллага нь тухайн криптовалютын төрлөөс хамааран санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэглүүр, орлого эсвэл нөөц байдлаар бүртгэж тайлагнаж болох үр дүнд хүрсэн бол хөрөнгө оруулагч байгууллага уг криптовалютыг ямар зорилгоор эзэмшиж байгаагаас нь хамааруулж биет бус хөрөнгө, бараа материал, санхүүгийн хөрөнгө гэж ангилан санхүүгийн

тайландаа тусгаж болох юм. Гэвч практик дээр бүртгэж тайлагнахад гарч байгаа гол асуудал нь хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй байдал юм.

Бид судалгаа болон хувийн үзэл бодолдоо тулгуурлан санал болгохдоо ойрын ирээдүйд криптовалют тэр дундаа Bitcoin, Ethereum зэрэг голлох валютууд төлбөрийн хэрэгсэл болж түгээмэл ашиглагдаж байгаа уламжлалт валютуудыг орлох боломжтой гэж үзэж байна.

Цаашдын судалгааны зүйл нь бүртгэлийн чиглэлээс гадна татварын бүртгэл болон криптовалютын үнэлгээний асуудал байвал илүү ач холбогдолтой цогц шийдэл болох юм.

Ашигласан материал

- Chaum, D. (1983). Blind Signatures for Untraceable Payments. In: Chaum, D., Rivest, R. L., & Sherman, A. T. *Advances in Cryptology*. Springer, Boston, MA, 199-203.
- Procházka, D. (2018). Accounting for Bitcoin and Other Cryptocurrencies under IFRS: A Comparison and Assessment of Competing Models. *The International Journal of Digital Accounting Research*, 18, 161-188.
- CPA Canada (2018). *Introduction to Accounting for Cryptocurrencies under IFRS*. Retrieved from: <https://www.cpacanada.ca/en/business-and-accounting-resources/financial-and-non-financial-reporting/international-financial-reporting-standards-ifs/publications/accounting-for-cryptocurrencies-under-ifs>
- Deloitte (2020). *Corporates Investing in Crypto: Considerations Regarding Allocations to Digital Assets*. Retrieved from: <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/us/Documents/audit/corporates-investing-in-crypto-microstrategy.pdf>
- Grant Thornton (2018). *IFRS Viewpoint: Accounting for Cryptocurrencies - The Basics*. Retrieved from: <https://www.grantthornton.global/globalassets/1.-member-firms/global/insights/article-pdfs/ifrs/ifrs-viewpoint-9---accounting-for-cryptocurrencies--the-basics.pdf>
- Keane, M. (2018). *IFRS: Accounting for Crypto-assets*. Retrieved from: <https://eyfinancialservicesthoughtgallery.ie/ifrs-accounting-crypto-assets/>
- KPMG (2019). *Cryptoassets - Accounting and Tax*. Retrieved from: <https://home.kpmg/xx/en/home/insights/2019/04/cryptoassets-accounting-flyer.html>

PWC (2021). *Cryptographic Assets and Related Transactions: Accounting Considerations under IFRS*. Retrieved from: https://viewpoint.pwc.com/dt/gx/en/pwc/in_depths/in_depths_INT/in_depths_INT/Cryptographic-assets-and-related-transactions-in-depth.html

Reyes, S. (2018). *Cryptocurrency: The Challenge for Accountants & Auditors*. Retrieved from: <https://ebra.be/wp-content/uploads/2018/08/deloitte-presentation-for-ecrf-june-2018.pdf>

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны Дарга, Сангийн Сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирлын хамтарсан тушаал А-63/64/32, А/27 (2021). *Сэндбокс зохицуулалтын орчны журам*.

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (2019). *СТОУС - 2018, А хэсэг*. Улаанбаатар.

Хавсралт 1. Улс орнуудын хууль, дүрмийн агуулга

№	Зөвхөн татварын хуультай	Зөвхөн мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхгүй байх хуультай	Татвар болон мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхгүй байх хуультай
1	Аргентин	Кайманы арлууд	Австрали
2	Австри	Коста Рика	Канад
3	Болгар	Чех	Дани
4	Финлянд	Эстон	Япон
5	Исланд	Гибралтар	Швейцарь
6	Израйль	Хонг Конг	
7	Итали	Жерси	
8	Норвеги	Латви	
9	Польш	Лихтенштейн	
10	Румын	Люксэмбург	
11	Орос	Сингапур	
12	Словак	Өмнөд Солонгос	
13	Өмнөд Африк		
14	Испани		
15	Швед		
16	Их Британи		

Эх сурвалж: <https://www.loc.gov/law/help/cryptocurrency/map1.pdf>